



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар A/56

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ний 4 дэх хэсгийн 4.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гишүүнчлэлийн журам”-аар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 10 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах арга хэмжээг 2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрхийг хязгаарлахыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2019 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн  
...*A/S6*... дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг түр хязгаарлах  
арга хэмжээ авагдах гишүүн үнэт цаасны компаниуд**

1. "Батс ҮЦК" ХХК
2. "Блюскай секьюритиз ҮЦК" ХК
3. "Ди си эф" ХХК
4. "Дэлгэрхангай секьюритиз ҮЦК" ХХК
5. "Зэт жи би ҮЦК" ХХК
6. "Капитал маркет корпораци ҮЦК" ХХК
7. "Масдак ҮЦК" ХХК
8. "Нэйшнл секьюритис ҮЦК" ХХК
9. "Эф си икс ҮЦК" ХХК
10. "Инвескор Капитал ҮЦК" ХХК

---oOo---